



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/05

Хатан суудал

Г Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг Г
хориглох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.1, 7.12.3, аймгийн Засаг даргын 2022 оын 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/09 тоот захирамж, Мал эмнэлгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 тоот албан бичиг зэргийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Отор нүүдэл, үйлдвэр худалдаа үржлийн болон бусад зорилгоор амьд мал, амьтан зөөвөрлөж, тээвэрлэн тус сумын нутаг дэвсгэрт байршуулахыг 2022 оны 06 дугаар сар хүртэл хориглосугай.

2. Мал амьтны шилжилт хөдөлгөөн, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр малчид, мал бүхий иргэдэд сурталчилж, мэдээллээр хангаж, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Н.Цэрэндолгор), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Б.Мөнхзаяа), Тархвар зүйч (А.Элдэв-Очир), Хэсгийн төлөөлөгч (Г.Эрдэнэбилэг), багийн Засаг дарга, Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хориглосонтой холбогдуулан өөрийн болон өөр аймаг, сумдаас амьд мал, амьтан худалдан авахгүй, зөөвөрлөж тээвэрлэхгүй байх, малын гоц халдварт өвчний шинж тэмдэг бүхий мэдээллийг шуурхай дамжуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байхыг малчид, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

642101313

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, захирамжийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ

